

АГУУЛГА

1. **ӨМНӨХ ҮГ**
2. **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ**
3. **СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД**
 - 3.1. Алсын хараа
 - 3.2. Эрхэм зорилго, эрхэмлэн дээдлэх зүйлс
 - 3.3. Орчны шинжилгээ
 - 3.3.1 Үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгчийн талаар хийсэн шинжилгээ
 - 3.3.2 Өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ
 - 3.3.3 Өнөөгийн бодлогын чиг хандлагын үнэлгээ
 - 3.3.3.1 Нийгмийн бодлогын хүрээнд
 - 3.3.3.2 Дэд бүтэц, хот байгуулалт, тохижилт, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд
 - 3.3.3.3 Эдийн засгийн бодлогын хүрээнд
 - 3.3.3.4 Төрийн байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд
 - 3.3.4 Засаг даргын тамгын газрын орчны шинжилгээ
 - 3.4 Тамгын газрын үйл ажиллагаа /бизнес/-ын стратегийн зорилт /ажил үйлчилгээний ерөнхий анги/
 - 3.5 Тамгын газрын үйл ажиллагаа /бизнес/-ын стратегийн зорилт /ажил үйлчилгээний ерөнхий анги/-ыг хэрэгжүүлэх нэгжүүдийн харилцан уялдаа холбоо, үйл ажиллагааны хамрах хүрээ
 - 3.5.1 Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
 - 3.5.2 Санхүү, төрийн сангийн хэлтэс
 - 3.5.3 Нийгмийн хөгжлийн хэлтэс
 - 3.5.4 Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтэс
 - 3.5.5 Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
 - 3.6.6 Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
 - 3.6.7 Цэргийн штаб
 - 3.6 Засаг даргын дэргэдэх харъяа хэлтэс, албадтай харилцах чиглэл
4. **ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО ХЭМЖЭЭ, ХУГАЦАА, ЧАНАР**
 - 4.1 Төсвийн жилд нийлүүлэх ажил үйлчилгээ
 - 4.2 Ажил үйлчилгээ нийлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ
 - 4.3 Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц
 - 4.4. Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын механизм
5. **ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
 - 5.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба төсвийн таамаглалын талаарх мэдэгдэл
 - 5.2.1 Төсвийн ерөнхий бодлогууд
 - 5.2.2 Төсвийн тусгай бодлогууд
 - 5.2.3 Төсвийн таамаглалын талаарх мэдээлэл
 - 5.3 Төлөвсөн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга
6. **ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД**

6.1 Санхүүгийн үйл ажиллагааны зорилт ба үзүүлэлтүүд

6.2 Нөөцийн ашиглалт ба сайжруулалт

6.2.1 Хүний нөөц

6.2.1.1 Боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилт

6.2.1.2 Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2017-2020 оны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

6.2.1.3 Ажилтны ажлын орчин нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг хангах чиглэлээр

6.2.1.3 Албан хаагчдын эрүүл мэнд, сургалт хөгжлийн асуудал

6.2.1.4 Албан хаагчдыг хөгжүүлэх бусад чиглэлээр

6.2.2 Биет хөрөнгийн нөөц

6.2.3 Санхүүгийн нөөц

6.3 Эрсдэл

6.3.1 Болзошгүй өр төлбөр

6.3.2 Хууль эрхийн актын үйлчлэлтэй холбоотой эрсдэл

6.3.3 Өмчлөлийн өөрчлөлт болон бодлогын өөрчлөлт

6.3.4 Гадаад валютын ханшны өөрчлөлтийн эрсдэл

6.3.5 Зээлийн эрсдэл



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН “ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”

ӨМНӨХ ҮГ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”-г Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Сангийн Сайдын 2003 оны 93 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол, холбогдох бусад хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдлөг болгон боловсруулсан болно.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” дараах бүрдлээс тухайлбал:

- ✚ Төсвийн шууд захирагчийн мэдэгдэл,
- ✚ Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилт /ажил үйлчилгээний ерөнхий анги, ойрын 3 жилд худалдан авах, нийлүүлэх ажил үйлчилгээ болон өмчлөлийн зорилтууд/,
- ✚ Дүүргийн Засаг даргын Тамгын газраас төсвийн жилд нийлүүлэх үйл ажиллагааны нэр төрөл, тоо хэмжээ, чанар, тэдгээрийн өртөг,
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу жилийн эцсийн тайлангийн ижил үзүүлэлтээр боловсруулсан Ажлын албаны төсөв буюу төлөвлөсөн баланс,
- ✚ Төсвийн шууд захирагчаас байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад зорилтуудаас бүрдэнэ.

Засаг даргын Тамгын газрын “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” нь өмнөх төлөвлөгөөнөөс дараах ажиллагааг илүү тодорхой болгосноороо ач холбогдолтой юм. Үүнд:

- ✚ Засаг даргын Тамгын газрын “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” нь дүүргийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтод суурилсан,
- ✚ Стратегийн зорилт буюу үйл ажиллагааны нэр төрлийг шинэчлэн томъёолсон,
- ✚ Бүтээгдэхүүнд бус үйл ажиллагаанд суурилсан,
- ✚ Ажил үйлчилгээ хоорондын уялдааг нягт холбосон,
- ✚ “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”-өөр тодорхойлогдсон ажил үйлчилгээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, ил тод нээлттэй байх зарчимд тулгуурласнаар дүүргийн Засаг дарга, Тамгын газраас дэвшүүлсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг хангахад бодит хувь нэмэр оруулна.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2016-2020 оны “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”-г боловсруулан, төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлж байна. Уг төлөвлөгөөнд:

- ❖ Тамгын газрын стратеги /алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчим, 2016-2020 онд дэвшүүлж буй стратегийн зорилтууд/,
- ❖ Тухайн жилд дүүргийн Засаг даргад Тамгын газраас нийлүүлэх ажил үйлчилгээ, түүний нэр төрөл, ажил үйлчилгээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа, тэдгээрийн шалгуур үзүүлэлт,
- ❖ Төсөвлөсөн санхүүгийн тайлан,
- ❖ Тамгын газрын боловсон хүчин, санхүү, материаллаг нөөцийн чадавхийг дээшлүүлэх, эд хөрөнгийн ашиглах, хамгаалахтай холбогдсон өмчлөлийн зорилтууд,
- ❖ Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн төсөвлөсөн тайлан зэргийг

багтаасан болно.

Төлөвлөгөөнд тусгагдсан дунд хугацааны зорилго, зорилт хүрэх үр дүнг хангахаар нийлүүлж буй ажил үйлчилгээ нь дүүргийн хөгжлийг хангах болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхэд шууд чиглэгдсэн юм. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас нийлүүлэх ажил үйлчилгээг тогтвортой мөрдөн, тухайн жилд нийлүүлэх ажил үйлчилгээний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх үр дүн, өртөг, түүнд шаардагдах төсвийн зардлын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргатай урьдчилан тохиролцсоноор жил бүр тодотгон боловсруулж, батлуулан ажиллана.

Төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах, хүрсэн үр дүнг цаашид баталгаажуулах, тогтвортой ахиулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, удаашралтай байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар мэргэжилтэн, ажилтан албан хаагчдыг үүрэг даалгавар, санал, зөвлөмжөөр хангахын зэрэгцээ Тамгын газрын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар дүүргийн иргэдэд нээлттэй мэдээллэн ажиллана.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.АМАРТҮВШИН

3. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

3.1 Алсын хараа

Төрийн өмчийн болон төрийн бус байгууллага, иргэн бүрт төрийн үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлэх, тэдний идэвх санаачлагыг дэмжих замаар дүүргийн хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлэх явдал мөн.

3.2 Эрхэм зорилго

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгч, Засаг дарга нарын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, ИТХ-ын ажлын алба болон Засаг даргын Тамгын газрын өндөр үр ашигтай, хэвийн жигд ажиллагааг баталгаажуулан, төрийн үйлчилгээг иргэн бүрт шуурхай хүргэх замаар дүүргийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлэхэд оршино

❖ Эрхэмлэн дээдлэх зүйлс

- ✓ Шинэчлэгч, санаачлагч, хэрэгжүүлэгч байх,
- ✓ Үйлчлэгч, түншлэгч, хүндэтгэгч байх,
- ✓ Бүтээлч, ил тод нээлттэй, хууль дээдлэгч, шударга ёсыг эрхэмлэгч байх,

3.3 Орчны шинжилгээ

3.3.1 Үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгчийн талаар хийсэн шинжилгээ

Тамгын газрын үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгчийн хүрээ заагийг үнэ зөв тодорхойлох нь орчны шинжилгээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд энэ нь Тамгын газрын зорилго, зорилтыг зөв тодорхойлох нөхцлийг бүрдүүлэх юм. Тамгын газраас ажил үйлчилгээ авахыг сонирхож буй үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгчийн байдалд судалгаа хийж, дараах үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгчийг тодорхойлов.

Тамгын газрын үндсэн хэрэглэгч, бусад хэрэглэгч

Засаг даргын Тамгын газрын хувьд Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ажлын албыг үндсэн хэрэглэгч гэнэ.

Иргэд, байгууллага, аж ахуй нэгж, төрийн болон бус байгууллагууд бусад хэрэглэгч байна.

3.3.2 Өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ

Эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, хүний эрхийг хангасан төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэдэг нутгийн захиргааны байгууллага нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ зөв бодлого, менежментийг баримтлан ажиллахыг гол чиг хандлагаа болгож байна.

Иймд иргэн бүрт хүрэх төрийн үйлчилгээний чиг хандлагыг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх богино, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах нь чухал юм. Учир нь дөрвөн жилийн хугацаагаар сонгогддог удирдлагын бүтцийг дагаад үйл ажиллагааны залгамж чанар алдагдах таагүй байдал үүсдэг тул дараагийн удирдлага өмнөх бодлогыг хадгалах, үргэлжлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд уг баримт бичиг ач холбогдолтой билээ.

3.3.3 Өнөөгийн бодлогын чиг хандлагын үнэлгээ

3.3.3.1 Нийгмийн бодлогын хүрээнд

Дүүргийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх, эмнэлэг, цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эрүүл мэнд, боловсрол салбарыг дэмжин хөгжүүлж, нийгмийн халамж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газар, НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын ажиллагааны хүрээнд “Хүүхдэд ээлтэй орон нутаг-Хүүхдэд ээлтэй дүүрэг” хөтөлбөрийг Баянзүрх дүүрэгт 2017-2021 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

3.3.3.2 Дэд бүтэц, хот байгуулалт, тохижилт, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд

Дүүргийн нутаг дэсгэрт агаар, хөрсний бохирдлыг бууруулж, ногоон хөгжлийг дэмжин, гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийж, дэд бүтцийг хөгжүүлэн, хог хаягдлын менежментийг нэвтрүүлэн, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх чиглэлээр бодлого барин ажиллаж байна.

2017 онд дүүргийн хэмжээнд 8 дэд станц байгуулагдснаар 414 цахилгаангүй, хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангаж ажилласан. 2017 онд дүүргийн хэмжээнд авто замын 4 ажил төлөвлөн гүйцэтгүүлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10 хорооны 14 байршилд явган хүний зам, хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэгийн тохижилтын ажлууд хийгдсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн

сан, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, зүлэгжүүлсэн бол иргэд, аж ахуйн нэгж байгууллага, орон сууц, гэр хорооллын айл өрхийн 119,646 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.

3.3.3.3 Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Дүүргийн Засаг даргын Тамгын газар энэхүү бодлогыг анхан шатны нэгжид хүргэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон эдийн засаг, санхүүгийн цогц бүтцийг бий болгох нөхцлийг бүрдүүлэхээр зорьж байна.

Дүүрэг нь худалдаа, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

3.3.3.4 Төрийн байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд:

Нийслэл, дүүргийн хэмжээнд эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэн, мэдээлэл технологид суурилсан мэдлэг боловсролыг дээшлүүлэх, иргэдийн эрэл хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

2018 онд иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газарт Угтах үйлчилгээг байгуулж, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил болгон ажиллаж байна.

-----Ω-----

3.3.4 Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын орчны шинжилгээ

<p style="text-align: center;">Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хүний нөөцийн чадавх сайн ✓ Үйл ажиллагаа явуулах орчин сайн ✓ Дүүргийн нутаг дэвсгэрт шинжлэх ухаан, батлан хамгаалах, урлаг соёлын байгууллага олноор төвлөрсөн ✓ Нийслэлд хүн амын тоогоор тэргүүлдэг ✓ Нутаг дэвсгэрийн хэмжээ ихтэй ✓ Орон сууц, гэр хороолол хосолсон ✓ Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын 50% нь 35 наснаас доош залуу албан хаагчид ажилладаг ✓ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн байрладаг ✓ Ногоон байгууламж бусад дүүргээс харьцангуй их ✓ Техник тоног төхөөрөмжийн шинэчлэл сайн 	<p style="text-align: center;">Сул тал</p> <ul style="list-style-type: none"> ○ Орон нутгаас шилжин ирэгсдийн тоо өсдөг тул дэд бүтэц султай гэр хороолол ихтэй ○ Ажилгүйдэл, ядуурал, хог хаягдлын хэмжээ ихтэй ○ Үйлдвэрлэл аж ахуйн томоохон байгууллага цөөн ○ Байгууллагын гадаад харилцаа сул ○ Цэцэрлэг, сургуулийн эрэлт ихтэй ○ Тухайн хороонд амьдардаг хүн амын нягтрал улсын дунджаас харьцангуй их ○ Алслагдсан хороодын иргэд төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй ○ Дүүргийн төсвийг бүрдүүлдэг татварын орлогын нэр төрөл цөөн
<p style="text-align: center;">Боломж</p> <ul style="list-style-type: none"> ✚ Нутаг дэвсгэрийн хэмжээ ихтэй ✚ Хөдөө аж ахуй, газар тариалан хөгжүүлэх боломжтой ✚ Нийслэлийн ундны усны эх үүсвэртэй ✚ Ажиллах хүчний нөөц ихтэй 	<p style="text-align: center;">Бэрхшээл</p> <ul style="list-style-type: none"> ■ Дүүргийн төсөв хүн амын тоонд харьцуулахад харьцангуй бага ■ Харьяа зарим хэлтэс, албад босоо удирдлагын тогтолцоотой тул үйл ажиллагааг нэг удирдлага дор төвлөрүүлэхэд бэрхшээлтэй ■ Санхүүгийн бие даасан эрх зүйн орчин бүрдээгүй



3.4 Тамгын газрын үйл ажиллагааны (бизнес)-ын стратегийн зорилт, ажил үйлчилгээний ерөнхий анги

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн тодорхойлсон эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн зорилтоо дараах байдлаар илэрхийлж байна.

Иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хороодын өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ

Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөв, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ

Хөрсний бохирдлыг бууруулж, ногоон хөгжлийг дэмжин, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

Хороод иргэддээ нээлттэй, иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг, дүүргийн үйл ажиллагаа ил тод, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд цогц хүртээмжтэй хүргэнэ

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангаж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ

3.5 Тамгын газрын үйл ажиллагааны (бизнес)-ын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх нэгжүүдийн харилцан уялдаа холбоо, үйл ажиллагааны хамрах хүрээ

Тамгын газар нь Засаг даргын ажлын алба бөгөөд бодлого төлөвлөлт, зохицуулалт, нутгийн захиргааны анхан шатны байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн үйлчилгээг хүргэхдээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /хууль зүйн тасаг, архивын тасаг, хэвлэл мэдээллийн алба, аж ахуйн

тасагтай/, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтэс /хяналт мониторингийн албатай/, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цэргийн штаб гэсэн үндсэн бүтэцтэйгээр стратегийг хэрэгжүүлнэ.

3.5.1 Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодыг төрийн удирдлагаар хангах, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хүний нөөцийн удирдлага, шагнал урамшуулал, Тамгын газрын гадаад харилцаа, мэдээлэл сурталчилгаа болон аж ахуй, зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлт, дотоод ажлыг хэвийн явуулах үйл ажиллагааг хангаж, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, тэдний эрэлт хүсэлт, санал, гомдол, нийгмийн асуудлыг хүлээн авч, эрх бүхий субъекттэй хамтран шийдвэрлэх, дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралтыг багасгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодыг арга зүйн удирдлагаар хангах, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албыг мэдээ, мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал зөвлөмж өгөх
- Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын үйл ажиллагааны эргэх холбоог хангаж ажиллана

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороод болон үндсэн бодлогын хэлтсийг захиргааны удирдлагаар хангаж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, дээд газарт хүргүүлэх

3.5.2 Санхүү, төрийн сангийн хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Төсвийн хуулийн хэрэгжилтийг хангаж, дүүргийн төсвийн дунд хугацааны төсөөлөл болон жилийн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, хуваарилах, санхүүжүүлэх, төсвийн үйл явцыг бодлогын удирдамжаар хангах, төлбөр тооцоог хийж гүйцэтгэх, тайлагнах, зарцуулалтад хяналт тавих, төсвийн өртөг зардал тооцох, нэгдсэн тайлан, баланс гаргах, судалгаа шинжилгээ хийх, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албыг төсөв санхүүтэй холбоотой мэдээллээр, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, аж ахуй нэгж байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал зөвлөмж өгөх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг даргын дэргэдэх хэлтэс албад төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийг зориулалтаар нь үр өгөөжтэй зарцуулахад хяналт тавих, санхүү нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хангуулах

3.5.3 Нийгмийн хөгжлийн хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Дүүргийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэн бүрийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, нийтийн биеийн тамир, соёл, нийгмийн халамж, хамгаалал, оролцоо бүхий нийгмийн үйлчилгээг тэгш зарчимд тулгуурлан, төрөөс гарсан хууль тогтоомж, бодлого шийдвэр, дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албад, хороодыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, нийгмийн хөгжлийн бодлоготой холбоотой асуудлаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй бодлогын чиглэлээр хамтран, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албыг мэдээ мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал, зөвлөмж өгөх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албад, хороодыг мэргэжил арга зүйгээр хангах, нийгмийн бодлогын чиглэлийг нэгтгэн, шууд харъяалагдах удирдлагад тайлагнаж, үндсэн бодлогын хэлтэстэй хамтран шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээллээр хангах

3.5.4 Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төлөвлөх,

тайлагнах, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулах, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнах, орон нутгийн хөгжлийн сан, гэр хорооллын дахин төлөвлөлтийг зохион байгуулж, орон нутгийн хөгжлийг тодорхойлон хэрэгжүүлэх

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, хороодыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, дүүргийн хөгжлийг тодорхойлоход иргэдийн оролцоог хангаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй хамтран, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний ажлын албыг мэдээ, мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал зөвлөмж өгөх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албад, хороодыг мэргэжил арга зүйгээр хангах, дүүргийн хөгжил, орон нутгийн хөгжлийн сан, гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар мэдээллээр хангах, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд бүх салбартай хамтран ажиллаж, үндсэн бодлогын хэлтэстэй хамтран, шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах

3.5.5 Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, хороод, худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, дээд байгууллагын тогтоол шийдвэрийг хангуулах, дүүргийн нутаг дэвсгэрт бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний талаар төрөөс явуулах бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хүнс, худалдаа, үйлчилгээний асуудлаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй бодлогын чиглэлээр хамтран, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний ажлын албыг мэдээ, мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал, зөвлөмж өгөх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албад, хороодыг мэргэжил арга зүйгээр хангах, дүүргийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг нэгтгэн, удирдлагад тайлагнаж, үндсэн бодлогын хэлтэстэй хамтран, шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээллээр хангах

3.5.6 Тохижилт, нийтийн ахуйн хэлтэс

Үйл ажиллагааны чиглэл: Монгол улсын Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлж, дүүргийн хүн амын байршил, бодит хэрэгцээтэй уялдуулан, дэд бүтцийг ойртуулан хөгжүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолыг бүх талаар хангахад чиглэсэн төрийн үйлчилгээг үзүүлэх

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгаль орчин, ногоон хөгжил, дэд бүтэц, тохижилтын асуудлаар Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй бодлогын чиглэлээр хамтран, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний ажлын албыг мэдээ, мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал, зөвлөмж өгөх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албад, хороодыг мэргэжил арга зүйгээр хангах, дүүргийн байгаль орчин, ногоон хөгжил, дэд бүтэц, тохижилтын чиглэлээр бодлогыг нэгтгэн, удирдлагад тайлагнаж, үндсэн бодлогын хэлтэстэй хамтран, шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээллээр хангах

3.5.7 Цэргийн штаб

Үйл ажиллагааны чиглэл: Дүүргийн хэмжээнд батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, цэрэг дайчилгааны нөхөн хангалт, гэрээт цэргийн ажлын байрыг нэмэгдүүлэх

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, цэргийн тоо бүртгэлийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, завсардагсдын тоог бууруулах, гэрээт болон

дүйцүүлэх хэлбэрээр цэргийн алба хаах идэвхийг иргэдийн дунд төлөвшүүлэх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороодыг мэргэжил, арга зүйгээр хангаж, бодлогын чиглэлийг нэгтгэн, удирдлагад тайлагнаж, үндсэн бодлогын хэлтэстэй хамтран, шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээллээр хангах, дээд газарт хүргэх

3.6 Засаг даргын дэргэдэх харъяа хэлтэс, албадтай харилцах чиглэл

Үйл ажиллагааны чиглэл: Үйл ажиллагааны чиг үүргийн дагуу дээд газар, эрх бүхий субъектийн гаргасан эрх зүйн акт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Тамгын газартай бодлогын чиглэлд хамтран, дүүргийн хөгжлийг тодорхойлон ажиллах

Үүрэг оролцоо:

- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ Засаг даргын Тамгын газрыг үйл ажиллагааны чиг үүргийн дагуу мэдээ, мэдээллээр хангах, Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын албаны шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Ажиллах чиглэл:

- Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний ажлын алба, Засаг даргын орлогч, Засаг даргын зөвлөх, Засаг даргын Тамгын газрын даргатай удирдлагын түвшинд харилцана
- Засаг даргын Тамгын газрыг үйл ажиллагааны чиг үүргийн дагуу мэдээ, мэдээллээр хангах, Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй бодлогын чиглэлээр хамтран, нийслэл, дүүргийн засаг даргын мөрийн хөтөлбөр, хэтийн төлөв, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, тайлагнах

4. ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО ХЭМЖЭЭ, ХУГАЦАА, ЧАНАР

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар 5 стратеги зорилт, 21 гол зорилт /буюу ажил үйлчилгээ/ тус бүрийн хүрээнд 82 ажил үйлчилгээг нийлүүлнэ.

Төсвийн жилд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийлүүлэх ажил үйлчилгээ бүрийг хавсралтаар батлах /Хавсралт 1/

-----Ω-----

4.2 Ажил үйлчилгээг нийлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар нийлүүлэх ажил үйлчилгээг тоо, хэмжээ, чанарын үзүүлэлтээр нийлүүлэхэд чиглэгдсэн дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

<p>❖ Төрийн байгууллагатай түншлэлийн сайн харилцааг хөгжүүлнэ</p>	<p>Эдийн засгийн зохистой бүтцийг бий болгоход чиглэгдсэн ажил үйлчилгээг нийлүүлэх чиглэлээр СЯ, ГХЯ, НЗДТГ болон түүний дэргэдэх агентлагуудтай, хүний хөгжлийг дэмжсэн, нийгмийн үйлчилгээг хүргэхэд чиглэгдсэн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр БСШУСЯ, БОАЖЯ-тай, дүүргийн тохижилт, дэд бүтэц, нийтлэг үйлчилгээ, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэгдсэн үйлчилгээг нийлүүлэх чиглэлээр БХБЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЭХЯ, төрийн захиргаа хүний нөөцийг боловсронгуй болгох, төрийн албан хаагчийн сургалт хөгжилтэй холбогдсон ажил үйлчилгээг нийлүүлэх чиглэлээр ТАЗ-ийн ажлын алба, Удирдлагын академи, сургалт судалгааны байгууллагатай тус тус хамтран ажиллана.</p>
<p>❖ Гадаад орон, олон улсын байгууллагатай түншлэлийн сайн харилцааг хөгжүүлнэ</p>	<p>Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх харъяа хэлтэс, албад, хороодын чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, төсвийн зардлын менежментийг сайжруулах, иргэдэд хүрэх үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын салбар байгууллагууд, Дэлхийн, сайн түншлэлийн харилцаатай гадаадын хотуудын шугамаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд тэдгээртэй ажил төрлийн сайн харилцаа тогтоож, нягт хамтран ажиллана.</p>
<p>❖ Иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилтэй сайн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ</p>	<p>Иргэн бүр ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг дэмжиж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлж, эдийн засгийн зохистой бүтэц бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, хүнсний аюулгүй</p>

	байдлыг хангаж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих замаар эрүүл, өв тэгш бие бялдартай иргэнийг төлөвшүүлэх, нутгийн захиргааны байгууллагыг бэхжүүлж, сонгодог шийдэл бүхий тохижилт, дэд бүтцийг бий болгон, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн сургалт хөгжилтэй холбогдсон ажил үйлчилгээг нийлүүлэх чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэлийн харилцаатай ажиллана.
❖ Тамгын газрын дотоод нэгжүүд, гадаад бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Засаг даргын Тамгын газрын дотор хэлтсүүдээс гадна бусад хэлтэс албадтай мэдлэг, мэдээллээ харилцан хуваалцаж, хамтран ажиллах нөхцлийг өргөжүүлэхийн зэрэгцээ харъяа хэлтэс, албадын үйл ажиллагааны чадавхи, ажлын үр дүнг дээшлүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үлгэр жишээ хэлтэс, албадыг сонгон шалгаруулна.
❖ Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын орон тооны бус зөвлөх үйлчилгээг бий болгоно	Засаг даргын Тамгын газрын үндсэн үйлчлүүлэгч, бусад хэрэглэгчийн зарим онцгой чухал хэрэгцээг хангахад чиглэсэн ажил үйлчилгээг нийлүүлэхэд шаардагдах үүднээс орон тооны бус зөвлөх баг байгуулан ажиллуулах замаар зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ. Мөн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсөв, цалингийн хэмнэлттэй холбоотойгоор ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан, урамшуулал олгох боломжийг ашиглана.
❖ Сургалт, суртчилгааны түнш байгууллагыг буй болгох нөхцлийг бүрдүүлнэ	Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг онол, практикийн өндөр түвшинд манлайлагч, үлгэр жишээ байгууллагыг сонгон шалгаруулж, тэдгээр байгууллагын практик, туршлагын жишээн дээр танилцах аялал, сургалт, семинар, мэдээлэл, суртчилгаа хийх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр зарим арга хэмжээ авч ажиллана.
❖ Төрийн захиргаа, төрийн алба, бусад чиглэлийн үйл ажиллагаатай холбогдсон хөтөлбөр, төсөл арга хэмжээг	Гадаад орон, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлж буй төрийн захиргаа, төрийн алба, бусад чиглэлийн үйл ажиллагаатай

уялдуулан зохицуулна	холбогдсон хөтөлбөр, төсөл арга хэмжээг уялдуулан зохицуулах замаар тэдгээрийн давхардал хийдлийг арилгах, зээл тусламжийн ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг түншлэлийн байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлнэ.
----------------------	---

Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц

Тамгын газрын дарга	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Хэлстийн дарга
		Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн
		Засаг даргын зөвлөлийн хурал, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
		Захиргааны зохион байгуулалт, Засаг даргын зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвөлгөөн хариуцсан мэргэжилтэн
		Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
		Шагнал, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
		Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлт хариуцсан мэргэжилтэн
		Хороо хариуцсан ахлах мэргэжилтэн
		Засаг даргын шуурхай ажил хариуцсан ажилтан
	Хэвлэлийн мэдээллийн алба	Хэвлэл мэдээллийн албаны дарга
		Сүлжээ хариуцсан мэргэжилтэн
		Техник хангамж, хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
		Цахим хуудас хариуцсан мэргэжилтэн
	Хууль зүйн тасаг	Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
		Тасгийн дарга
		Эрх зүйн маргааны шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн
		Захирамжлалын баримт бичиг, гэрээ хариуцсан мэргэжилтэн
	Архив, бичиг хэргийн тасаг	Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
		Тасгийн дарга
		Албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалт хариуцсан ажилтан
Архивч		
Аж ахуйн тасаг	Бичээч	
	Тасгийн дарга	

		Ахлах нягтлан бодогч
		Тооцооны нягтлан бодогч
		Хөрөнгийн нягтлан бодогч
		Нярав /2/
		Угтагч
	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хэлтсийн дарга
		Ерөнхий ня-бо
		Төрийн сангийн ахлах мэргэжилтэн
		Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн
		Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн
		Сургалт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн
		Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн
		Зарлага хариуцсан төсвийн мэргэжилтэн
		Салбар хариуцсан төсвийн мэргэжилтэн
		Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
		Санхүүжилт хариуцсан мэргэжилтэн
	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтэс	Хэлтсийн дарга
		Индекс, гэр хорооллын дэд бүтцийн хөгжил хариуцсан мэргэжилтэн
		Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл хариуцсан мэргэжилтэн
		Төсөл хөтөлбөр, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		
Хяналт, мониторингийн алба	Албаны дарга	
	Дотоод хяналт, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	
	Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	
Нийгмийн хөгжлийн хэлтэс	Хэлтсийн дарга	
	Соёл урлаг, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	
	Халамж, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн	
	Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир хариуцсан ахлах мэргэжилтэн	
	Хүүхэд, залуучууд гэр бүл хариуцсан мэргэжилтэн	
	Боловсрол, төрийн бус байгууллага, хариуцсан мэргэжилтэн	
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Хэлтсийн дарга	
	Гэрэлтүүлэг, хот тохижилт хариуцсан мэргэжилтэн	
	Байгаль орчин, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн	
	Зам, тээвэр, барилга байгууламж, холбоо хариуцсан мэргэжилтэн	
	Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	
	Сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан	

		мэргэжилтэн
		Төхижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн
	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Хэлтсийн дарга
		Худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
		Нийтийн хоол, зочид буудал хариуцсан ахлах мэргэжилтэн
		Үйлдвэрлэл, иноваци хариуцсан мэргэжилтэн
		Аялал жуулчлал, ахуй үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
		Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн
		Авто засвар, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	Цэргийн штаб	Штабын дарга
		Тоо бүртгэлийн офицер
		Төлөвлөлт, сургалтын офицер
		Мэдээллийн аюулгүй байдлын офицер
		Дайчилгааны офицер
		Шуурхай байдлын ахлагч

4.4 Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын механизм

4.4.1 Санхүүгийн хяналт:

Засаг даргын Тамгын газар нь аливаа ажил үйлчилгээг дагалдаж гарах санхүүгийн болон анхан шатны баримт бүрдэл дээр Төсвийн шууд захирагч, ахлах нягтлан бодогч гарын үсэг зурж баталгаажуулж ажиллана.

Төсвийн тухай хуулийн 54.3-д зааснаар Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах бөгөөд санхүүгийн тайлан нь дараах зүйлсээс бүрдэнэ.

- ✓ Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан
- ✓ Санхүүгийн байдлын тайлан
- ✓ Мөнгөн гүйлгээний тайлан
- ✓ Өмчийн өөрчлөлтийн тайлан
- ✓ Санхүүгийн тайлангийн тодруулга

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайланд дараах нэмэлт тодруулгыг хавсаргана.

- ✓ Байгууллагын тооцоо нийлсэн акт
- ✓ Баталгаа хохирлыг нөхөн төлөх үүрэг зэрэг тухайн байгууллагын учирч болзошгүй өр төлбөрийн тухай мэдэгдэл
- ✓ Батлагдсан төсвөөс гадуур буюу хэтрүүлж гаргасан зардлын тухай мэдэгдэл,
- ✓ Батлагдсан төсвийн зүйл бүрээр гаргасан зардлын дүн,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримталах бодлогын тухай тайлбар,
- ✓ Тухайн жилийн санхүүгийн үйл ажиллагааны дүн, жилийн эцсийн санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэхэд шаардлагатай мэдээлэл,

- ✓ Холбогдох тайлан болон мэдэгдэлд заасан үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний үзүүлэлтэд хүрсэн байдал,
- ✓ Холбогдох тайлан болон мэдэгдэл бүрээр өмнөх санхүүгийн жилд хүрсэн түвшин,
- ✓ Санхүүгийн тайлангийн үнэн зөв болохыг тодорхойлж ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэг зурсан мэдэгдэл.

Улсын төсвийн байгууллага хагас, бүтэн жилээр ажил үйлчилгээний анги тус бүрээр тоо хэмжээ, чанар, өртөг болон хугацааны биелэлтийг тусгасан үр дүнгийн гэрээний тайланг гаргана.

Засаг даргын Тамгын газар жилийн эцсийн тайлангаар төрийн Аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

Улирлын тайланд дараах зүйлсийг тусгана.

- ✓ Тухайн жилийн ажил үйлчилгээний нийлүүлэлтийн явц
- ✓ Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн явцыг дүгнэхэд шаардлагатай бусад мэдээлэл

4.4.2 Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дотоод хяналт:

- ✓ Тамгын газрын үйл ажиллагаанд ИТХурал, Засаг дарга, Дотоод аудит хяналт шинжилгээ мониторингийн албаны хяналт
- ✓ Ажилтан бүрийн 14 хоног тутмын ажлын явцыг түргэтгэх тайлан
- ✓ Улирал бүрийн санхүүгийн тайлангийн талаар төсвийн ерөнхийлөн захирагчаас өгсөн удирдамж чиглэл

4.4.3 Засаг даргын Тамгын газрын даргын гаргах шийдвэр, түүнийг боловсруулах үйл явц.

- ✓ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2-т заасны дагуу бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана. Тушаалыг холбогдох мэргэжилтэн боловсруулж, нэгжийн дарга, эрх зүйн хүрээнд тушаал гаргана. Тушаалыг холбогдох мэргэжилтэн боловсруулж нэгжийн дарга, эрх зүйн мэргэжилтэн хянан, Тамгын даргаар батлуулж мөрдөнө.

4.4.4 Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хяналт тавьж, биелэлтийг ханган ажиллана.

5.ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

5.1 Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд зарцуулахаар төсөвлөсөн санхүүгийн тайлангийн таамаглалын тухай мэдэгдэл

Төсвийн шууд захирагч Б.Амартүвшин, ахлах нягтлан бодогч Д.Өлзийцэцэг бид Засаг даргын Тамгын газрын 2017-2020 онуудад төсөвлөсөн санхүүгийн тайланд тусгасан үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг үнэн зөв тусгасан болохыг баталж байна. Үүнд:

- ✓ Төсөвлөсөн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв,
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг хамруулахыг хичээсэн,
- ✓ Төсөвлөсөн санхүүгийн тайлан нь иж бүрэн

Тамгын дарга бөгөөд
төсвийн шууд захирагч

/Б.Амартүвшин/

Ахлах нягтлан бодогч

/Д.Өлзийцэцэг/

5.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба төсвийн таамаглалын талаарх мэдэгдэл

5.2.1 Бүртгэлийн ерөнхий бодлого:

Төсвийн байгууллагууд төсөв ба нягтлан бодох бүртгэлийн хувьд ижил зарчимд суурилсан бие даасан санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагатай бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт ба үр дүнд суурилсан, Төсвийн тухай хуультай нийцсэн байна. Иймд Засаг даргын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төсөв ба төсөвлөсөн санхүүгийн тайланг үр дүнд суурилсан зарчмаар гаргалаа.

2018-2020 оны төсвийн таамаглалыг Статистик мэдээ, урьд жилүүдийн төсвийн гүйцэтгэлд суурилан боловсруулсан болно.

5.2.2 Бүртгэлийн тусгай бодлогууд

Орлогыг олсон цаг хугацаатай нь хамааруулан хүлээн зөвшөөрнө.

Бүтээгдэхүүний өртгийг тооцоолох:

- ✓ Ажилтнуудын 2017 оны хүн өдрийн хуваарьт үндэслэн ажил үйлчилгээний шууд зардлыг оноосон.
- ✓ Зардал тооцох суурийг ашиглан шууд бус зардлыг ажил үйлчилгээнд хуваарилсан.
- ✓ Үндсэн хөрөнгийг анхны өртөг буюу түүхэн өртгөөс нь хуримтлагдсан элэгдлийг хасаж цэвэр дүнгээр харуулсан.
- ✓ Жилийн амралтын зардлыг хуримтлуулан тусгасан.

5.2.3 Төсвийн таамаглалын талаарх мэдээлэл

- ✓ 2017-2020 онуудын төсөвлөсөн баланс,
- ✓ 2017-2020 онуудын төсөвлөсөн мөнгөн гүйлгээний төсөв,
- ✓ 2017-2020 онуудын өмчийн өөрчлөлтийн төсөвлөсөн тайлан.



5.3. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга

Үйл ажиллагааны төсөв болон төсөвлөсөн санхүүгийн тайлангуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-с үзнэ үү. Үүнд:

1. Хавсралт	0-1	Цалин хөлсний зардлын нэгтгэл
2. Хавсралт	0-2	Бичиг хэргийн зардлын төсөв
3. Хавсралт	0-3	Тээвэр шатахууны зардлын төсөв
4. Хавсралт	0-4	Шуудан холбооны зардлын төсөв
5. Хавсралт	0-5	Гадаад албан томилолтын зардлын төсөв
6. Хавсралт	0-6	Ном, хэвлэлийн зардал
7. Хавсралт	0-7	Гадаад зочны зардлын төсөв
8. Хавсралт	0-8	Мэдээлэл сурталчилгааны зардлын төсөв
9. Хавсралт	0-9	Түрээсийн төлбөрийн зардлын төсөв
10. Хавсралт	0-10	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн төсөв
11. Хавсралт	0-11	Нэг удаагийн тэтгэмж , шагнал урамшууллын зардлын төсөв
12. Хавсралт	Б-1а	2018 оны зардлын төсөв бүлэглэлээр
13. Хавсралт	Б-1б	2018 онд нийлүүлэх ажил үйлчилгээний нийт өртөг
14. Хавсралт	Б-2	Зардлын төвүүдэд хувиарлагдсан шууд зардлууд
15. Хавсралт	Б-3	Ажил үйлчилгээнд хувиарлагдсан шууд зардлууд
16. Хавсралт	Б-4	Зардлын төвүүдэд хувиарлагдсан шууд бус зардлууд
17. Хавсралт	Б-5	Ажил үйлчилгээний хүн өдрийн зарцуулалт
18. Хавсралт	Б-6	Ажил үйлчилгээний хүн өдрийн зарцуулалт (хувиар)

6. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД

6.1 Санхүүгийн үйл ажиллагааны зорилт ба үзүүлэлтүүд

Батлагдсан төсвийн зардлын зүйл ангиар зарцуулж, Тамгын газрын тасралтгүй үйл ажиллагааг ханган харилцагч байгууллагуудтай улирал тутам тооцоо нийлж, цаг хугацаанд нь сарын мэдээ, улирлын тайланг гарган өгнө.

6.2 Нөөцийн ашиглалт, сайжруулалт

Дүүргийн Засаг даргын Тамгын газар дээр тодорхойлсон өмчлөлийн зорилтыг хангахдаа боловсон хүчний биет хөрөнгийн болон санхүүгийн нөөцийн ашиглалт, үр ашгийг дээшлүүлэх, шинээр нөөц бүрдүүлэх асуудлыг дор дурьдсан байдлаар хэрэгжүүлэх болно.

6.2.1 Хүний нөөц

2017 онд Засаг даргын Тамгын газарт 305 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас Улс төрийн албан тушаалтан 32, төрийн захиргааны албан хаагч 126, төрийн үйлчилгээний ажилтан 141, төрийн тусгай 6 тус тус ажиллаж байна.

Ажилчдын тоог хэлтэс, албадаар харуулбал:

№	Хэлтэс албадын албан хаагчид	Тоо
1	Засаг дарга	1
2	Засаг даргын орлогч	1
3	Засаг даргын зөвлөх	3
4	Тамгын дарга	1
5	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	8
6	Хэвлэл мэдээллийн алба	5
7	Хууль зүйн тасаг	4
8	Архивын тасаг	4
9	Аж ахуйн тасаг	33
10	Санхүү, төрийн сангийн хэлтэс	12
11	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтэс	5
12	Хяналт мониторингийн алба	3
13	Нийгмийн хөгжлийн хэлтэс	6
14	Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс	7
15	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	7
16	Цэргийн штаб	6
17	Хороодын Засаг дарга нар	27
18	Хороодын зохион байгуулагч	42
19	Хороодын нийгмийн ажилтан	27
20	Хороодын үйлчлэгч, жижүүр	103
	Нийт дүн	305

Нийслэлийн Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын төрийн албан хаагчдийн 10,5 хувь нь улс төрийн, 42,3 хувь нь төрийн захиргааны, 45,2 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч 2 хувь нь төрийн тусгай албан хаагчид байна.

6.2.1.1 Боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилт

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн баталгааг хангах талаар 2017-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг 2017 онд баталсан.

